



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/071-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ХАЛАМЖИЙН САНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	
4. Аудитын тайлан	
4.1 Ерөнхий зүйл	
4.2 Материаллаг байдал	
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	
5. Аудитын илрүүлэлт	
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.15 № 01/35
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол улсыг хөгжүүлэх дунд хугацааны бодлогын баримт бичиг, Монгол улсын үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээг хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх зорилт, арга хэмжээ тусгагдсаны дагуу ХНХЯ-ын сайдын тушаалаар нийгмийн халамж үйлчилгээг цахимд шилжүүлэх ажлыг хэсэг байгуулагдан ажилласан байна.

Нийгмийн халамж үйлчилгээг 2020 онд 6 үйлчилгээ, 2021 онд 21 үйлчилгээ, 2022 онд 45 үйлчилгээг цахимд шилжүүлж, 2023 онд И-Халамж системийн хөгжүүлэлт, сайжруулалтыг ажлыг үе шаттайгаар гүйцэтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Төв аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын Халамжийн санд төсвийг санхүүжилтийг тайлант онд 2 арга хэмжээний зардлыг санхүүжүүлэхээр 94,562.9 мянган төгрөг олгож, онцгой тохиолдлын олон нийтийн оролцоонд түншилсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөлд

G/Архив/Албан бичиг 2024/ А4

0190.0022

сумдаас санхүүжилт авах хүсэлт ирээгүйгээс 56,576.5 мянган төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс нэмж аваагүй байна.

- Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 94,562.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, зарцуулаагүй үлдэгдэл 19,762.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.
- Монгол Улсын Засгийн Газраас хэрэгжүүлж байгаа Цахим Монгол хөтөлбөрийн хүрээнд халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлж Халамжийн нэгдсэн систем буюу ehalamj.mn цахим системийг нэвтрүүлсэн байна. Сангийн яам, Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам болон Гааль, Татвар Санхүүгийн Мэдээллийн Технологийн Төвтэй хамтран ehalamj.mn цахим системийг хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламжийн мөнгө Сангийн яамнаас иргэдийн арилжааны банкин дахь дансанд шууд ордог болсон учраас улсын төсвөөс санхүүжилт олгоогүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0	0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0	0
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0	0
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0	0
31210	Төгрөг	0	0
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0	0
33	АВЛАГА	0	0
33500	Бусад авлага	0	0
33600	Зээлийн авлага	0	0
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	0	0
34	УРЬДЧИЛГАА	0	0
34710	Урьдчилгаа тооцоо	0	0
35	БАРАА МАТЕРИАЛ	0	0
35100	Түүхий эд материал	0	0
35400	Хангамжийн материал	0	0
36	НӨӨЦИЙН БАРАА	0	0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	0	0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0	0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0	0
39100	Газар	0	0
39200	Биет хөрөнгө	0	0
39300	Биет бус хөрөнгө	0	0
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0	0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0	0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	0
41300	Өглөг	0	0
41360	Бусад өглөг	0	0
41400	Урьдчилж орсон орлого	0	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0	0
51	Засгийн газрын хувь оролцоо	0	0
51200	Хуримтлагдсан үр дүн	0	0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0	0

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	151,139,400.00	94,562,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	151,139,400.00	94,562,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	151,139,400.00	94,562,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	151,139,400.00	94,562,900.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	151,139,400.00	94,562,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	151,139,400.00	94,562,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	151,139,400.00	94,562,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,585,000.00	74,800,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	70,585,000.00	74,800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	80,554,400.00	19,762,900.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	80,554,400.00	19,762,900.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	151,139,400.00	94,562,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	151,139,400.00	94,562,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	151,139,400.00	94,562,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	151,139,400.00	94,562,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	151,139,400.00	94,562,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	151,139,400.00	94,562,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	151,139,400.00	94,562,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,585,000.00	74,800,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	70,585,000.00	74,800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	80,554,400.00	19,762,900.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	80,554,400.00	19,762,900.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	0	0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	0	0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	0	0
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	0	0
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0	0	0	0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	0	0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	0	0
20	2023 оны 12-р сарын 30-наарх үлдэгдэл	0	0	0	0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	151,139,400.00	74,800,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	151,139,400.00	74,800,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	151,139,400.00	74,800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	151,139,400.00	74,800,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	151,139,400.00	74,800,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	151,139,400.00	94,562,900.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	151,139,400.00	94,562,900.00
320001	Орон нутгийн төсвөөс	151,139,400.00	94,562,900.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□		0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□		0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн үйл ажил ажиллагааг халамжийн сангийн хэлтсийн дарга, нийгмийн халамжийн сангийн мэргэжилтэн, өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн судалгаа, өргөдөл гомдол, хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа, хүүхдийн мөнгө хариуцсан мэргэжилтэн, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, зорилтот бүлгийн хүн ам өрхийн хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд тус тус явуулсан байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сан нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сан нь нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламж дэмжлэгийг зорилтот бүлгийн иргэдэд хууль тогтоомж, бодлого шийдвэр, журмын дагуу хүргэх зорилт тавин ажилласан байна.

Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол улсыг хөгжүүлэх дунд хугацааны бодлогын баримт бичиг, Монгол улсын үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээг хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх зорилт, арга хэмжээ тусгагдсаны дагуу ХНХЯ-ын сайдын тушаалаар нийгмийн халамж үйлчилгээг цахимд шилжүүлэх ажлыг хэсэг байгуулагдан ажилласан байна.

Нийгмийн халамж үйлчилгээг 2020 онд 6 үйлчилгээ, 2021 онд 21 үйлчилгээ, 2022 онд 45 үйлчилгээг цахимд шилжүүлж, 2023 онд И-Халамж системийн хөгжүүлэлт, сайжруулалтыг ажлыг үе шаттайгаар гүйцэтгэсэн байна.

Тус газар нь тайлант онд нийгмийн халамжийн үйлчилгээний талаар тусгагдсан 16 зорилт арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэн 90,6 хувьтай дүгнэгдсэн байна.

Байгууллагын гадаад, дотоод орчин

Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 12 дугаар зүйл
- Төсвийн тухай хуулийн 4, 8, 10, 12, 23, 24, 28, 30 дугаар зүйл,
- Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар бүлэг, 4, 11, 13, 20, 41, 57, 59, 66 дугаар зүйл

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3, 8, 46 дугаар зүйл

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн "Дотоод хяналтын нэгж томилох тухай" А/09 тушаалаар шинэчлэн томилж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын даргын 2020 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн А/158 тоот тушаалаар "Дотоод хяналт зохион байгуулалтын журам" боловсруулан баталж, мөрдөн ажилласан байна.

Байгууллагын дотоод хяналтын календарчилсан төлөвлөгөө, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн "Хяналт шалгалтын нэгдсэн удирдамж хүргүүлэх тухай" 05/583 тоот албан бичиг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын 2021 оны А/103 тушаалаар батлагдсан хүнсний эрхийн бичиг олгох журмын хүрээнд хяналт шалгалтыг хийж зөвлөмж өгч ажилласан ч, орон нутгийн төсвөөс санхүүжиж байгаа олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төслийн хэрэгжилт, зардлын зарцуулалтын тайлан, анхан шатны материалын бүрдүүлэлтэд дотоод хяналт шалгалтыг хийгээгүй байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газрын Халамжийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газрын Халамжийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн №А/289 тоот тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс мөрдөж эхэлсэн байна. Энэхүү

баримт бичигт Халамжийн сангийн бүртгэл тайлагналын бүртгэлийн үйл ажиллагааг 4 бүлэгт тусгасан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газрын Халамжийн сангийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллага нь Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газрын харьяа хэлтэс учраас хөрөнгө, материал нь харьяа байгууллагын санхүү дээр бүртгэлтэй, орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтийг зарцуулж, үлдэгдэл мөнгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн тул мөнгөн хөрөнгийн үлдэгдэл болон бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэл байхгүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 151,139.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн шууд захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийн саналаас 151,139.4 мянган төгрөгөөр олон нийтийн оролцоонд түншилсэн халамжийн үйлчилгээ, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг санхүүжүүлэхээр ирүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр олон нийтийн оролцоонд түншилсэн халамжийн үйлчилгээнд 50,539.4 мянган төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалтад 100,600.0 мянган төгрөг нийт 151,139.4 мянган төгрөгийг Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлан ирүүлсэн байна.

Төв аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын Халамжийн санд төсвийг санхүүжилтийг тайлант онд 2 арга хэмжээний зардлыг санхүүжүүлэхээр 94,562.9 мянган төгрөг олгож, онцгой тохиолдлын олон нийтийн оролцоонд түншилсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөлд сумдаас санхүүжилт авах хүсэлт ирээгүйгээс 56,576.5 мянган төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс нэмж аваагүй байна.

Монгол Улсын Засгийн Газраас хэрэгжүүлж байгаа Цахим Монгол хөтөлбөрийн хүрээнд халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлж Халамжийн нэгдсэн

систем буюу ehalamj.mn цахим системийг нэвтрүүлсэн байна. Сангийн яам, Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам болон Гааль, Татвар Санхүүгийн Мэдээллийн Технологийн Төвтэй хамтран ehalamj.mn цахим системийг хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламжийн мөнгө Сангийн яамнаас иргэдийн арилжааны банкин дахь дансанд шууд ордог болсон учраас улсын төсвөөс санхүүжилт олгоогүй байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 94,562.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, зарцуулаагүй үлдэгдэл 19,762.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 94,562.9 мянган төгрөг буюу 62,6 хувьтай байгаа нь олон нийтийн оролцоонд түншилсэн халамжийн үйлчилгээнд 40,539.4 мянган төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 35,800.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Орон нутгийн төсөв:					
1	Оролцоонд түншилсэн халамжийн үйлчилгээнд 71902-80708	50,539.4	10,000.0	40,539.4	19.78%
2	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 71902-80709	100,600.0	64,800.0	35,800.0	64.41%
	Дүн	151,139.4	74,800.0	76,339.4	49.49%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын Халамжийн сан тайлант онд нэмэлт төсвийн гүйцэтгэл байхгүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

						/мянган төгрөгөөр/	
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан	
Орон нутгийн төсвөөс							
1	Нийгмийн халамжийн үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн өрх, өрхийн гишүүн- иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох, төсөлд хамруулах, амьдрах	Нийгмийн халамжийн үйлчилгээний олон нийтийн оролцоонд түншилсэн халамжийн үйлчилгээ, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 49.49%	151,139.4	74,800.0	

		ухаанд чиглэгдэнэ.	сургахад			
--	--	-----------------------	----------	--	--	--

Төв аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын Халамжийн сангийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг нийгмийн халамжийн сангийн нөхцөлт мөнгөн тэтгэмжийн олголт хөтөлбөрын хэрэгжилт 49,5% байна.Үүнд:

1.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ тайлант онд нийт 28 өрхийн 14 төсөл ирсэнээс төслийн газар тариалан, хүлэмжийн ногоо тариалах чиглэлээр ирсэн ба төсөл хэрэгжих улирал нь дууссан, материалын бүрдэл дутуугаас төслүүд хасагдаж, 5 бүлгийн төсөл шалгарч санхүүгийн дэмжлэг авснаас шалтгаалсан байна.

2.Орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж нь гэнэтийн аюул ослоос болж гэр оронгүй болсон, амьжиргааны эх үүсвэрээ алдсан 36 өрх, иргэнд 43.2 сая төгрөг, хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй 6 иргэнд 7.2 сая төгрөг, 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны 12 иргэнд 14.4 сая төгрөг, тайлант онд хүсэлт гаргасан нийт 534 иргэнд санхүүжилт олгосон байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага тайлант онд худалдан авсан бараа үйлчилгээ байхгүй байна.

4.АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой шилэн данс, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн зарцуулалтын баримт бүрдүүлэлтэй холбоотой зөвлөмж өгсөн болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 23 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2023 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2023 оны төсвийг, суурь үзүүлэлтийг 2023 оны 151,000.0 мянган төгрөгийн нийт батлагдсан төсвийн зардлаас 1,0 хувиар буюу 1,510.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,132.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 79.8%-тай, 5,0 саяас дээших орлогын 7 гүйлгээ байршуулж, үүнээс 6 орлогын гүйлгээ хугацаа хоцроож, зарлагын 7 гүйлгээ байршуулахаас 1 гүйлгээ хугацаа хоцроож байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн санд бусад хууль тогтоомжийн хүрээнд гарсан асуудал байхгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн сангийн завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн санд өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж байхгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын Халамжийн санд дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 66,379.6 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Тус байгууллага тайлант онд Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний 18.1.9 дахь заалтаар хийсэн ажил гүйцэтгэх гэрээний 3.6, 3.7 дахь заалтууд хэрэгжилт дутуу, төсөл хэрэгжүүлэгч нараас ирүүлсэн зардлын анхан шатны баримт, тайлан хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэлтийг хангах

2. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

2. Тус байгууллага тайлант онд шилэн дансанд 5,0 саяас дээших орлогын 50,379.6 мянган төгрөгийн 6 гүйлгээ, зарлагын 6,000.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, хугацаанд нь мэдээллийн байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажил гүйцэтгэх гэрээний 3.6, 3.7 дахь заалтууд хэрэгжилт дутуу, төсөл хэрэгжүүлэгч нараас ирүүлсэн зардлын анхан шатны баримт, тайлан хангалтгүй байна.							1	10,000.0
Дүн							1	10,000.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд 5,0 саяас дээших орлогын 50,379.6 мянган төгрөгийн 6 гүйлгээ, зарлагын 6,000.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ хугацаа хоцроож байршуулсан байна	1	56,379.6					1	56,379.6
Дүн	1	56,379.6					1	56,379.6
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	56,379.6					1	56,379.6

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn